



МОНГОЛ УЛС
ДҮНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 29 өдөр

Дугаар A/193

Мандалговь

Г Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой Онцгой комиссын 2020 оны 27 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн хугацааг сунгасантай холбогдуулан жагсаал цуглаан, нийтийг хамарсан спортын арга хэмжээ, цахим тоглоомын газар, диско болон бүжгийн баарны үйл ажиллагааг 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд хориглосугай.

Хоёр. Дээр зааснаас бусад бүх төрлийн тоглоомын газар, баар, биллиард, шашин, соёл урлаг, үзвэр үйлчилгээний газрын үйл ажиллагааг шинэ коронавирус (КОВИД-19)-өөс урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар зөвлөмжийг мөрдлөг болгон халдварт хамгааллын дэглэмийг чанд мөрдөн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсүгэй.

Гурав. Захирамжийг мөрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга (М.Адъяабаатар), Цагдаагийн газрын дарга (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат), Эрүүл мэндийн газрын дарга (Г.Бат-Орших) болон холбогдох байгууллага, аж ахуй нэгжийн дарга, удирдлага, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ж.МӨНХЧУЛУУН



482010530